


Улаанбаатар хот
ДҮҮРГҮҮДИЙН ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫН ТАЙЛАН

2019



ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS
RESEARCH CENTER

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ



The Asia Foundation

ДАА-330
ННА-65
У-295

УЛААНБААТАР ХОТ ДҮҮРГҮҮДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАН 2019

Улаанбаатар хот. 2019 он.

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

Сан бизнес центр, 9-р давхар, Ерөнхий сайд Амарын гудамж 29
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Утас: 976-11-321927
Факс: 976-11-321926

Цахим шуудан: info@ecrc.mn
Цахим хуудас: www.ecrc.mn | www.aimagindex.mn | www.nogoonhutuch.mn
Фэйсбүүк хуудас: www.facebook.com/ecrcmn
Твиттер хуудас: twitter.com/ursulduhchadvar

Хавтас болон ерөнхий дизайн: Бату Дижитал **BATU**[™]
“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-99978-4-402-6

© Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. Бүтээлийг зөвшөөрөлгүйгээр бүтнээр болон хэсэгчлэн хувилах, нийтлэх, ямар нэг хадгалах системд оруулахыг хориглоно.

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	4	3.1	БАГАНУУР ДҮҮРЭГ	44
МЭНДЧИЛГЭЭ	6	3.2	БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ	52
ТОВЧИЛСОН НЭРСИЙН ЖАГСААЛТ	8	3.3	БАЯНГОЛ ДҮҮРЭГ	60
СУДАЛГААНЫ БАГ	8	3.4	БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ	68
УДИРТГАЛ	9	3.5	НАЛАЙХ ДҮҮРЭГ	76
01 СУДАЛГААНЫ ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ	14	3.6	СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ	84
1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО	15	3.7	СҮХБААТАР ДҮҮРЭГ	92
1.2 ДҮҮРГҮҮДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД	16	3.8	ХАН-УУЛ ДҮҮРЭГ	100
1.3 МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР	19	3.9	ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ	108
1.4 СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ	20	3.10	УЛААНБААТАР	116
1.5 ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКС ТООЦОХ АРГАЧЛАЛ	25	04 СТАТИСТИК ХҮСНЭГТҮҮД	122	
02 ДҮҮРГҮҮДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ	28	4.1	АМЬДРАЛЫН ЧАНАР	125
2.1 ДҮҮРГҮҮДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ЕРӨНХИЙ ИНДЕКС	30	4.2	АМЬДРАХ ОРЧИН	134
2.2 ДҮҮРГҮҮДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН БҮЛГИЙН ИНДЕКС	31	4.3	АЮУЛГҮЙ БАЙДАЛ	148
2.3 ДҮҮРГҮҮДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ДЭД БҮЛГИЙН ИНДЕКС	36	4.4	ЗАСАГЛАЛ	157
03 ДҮҮРГҮҮДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ ...	42	4.5	ЭДИЙН ЗАСАГ	166
		05 ХАВСРАЛТ	170	
		5.1	ДҮҮРГҮҮДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	172
		5.2	ТҮҮВРИЙН ЕРӨНХИЙ ШИНЖ	192



Нийслэлийн дүүргүүдийн өрсөлдөх чадварын судалгааны 2 дахь тайланг Сар шинийн баяраар олон нийтийн хүртээл болгож буйдаа баяртай байна.

Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайланг хоёр жилийн өмнө анх танилцуулсан нь тэдэнд ямар түвшинд байгаагаа танин мэдэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг. Үүний тул судалгааг гүнзгийрүүлсэн энэ удаагийн тайлангаар дүүргүүдэд гарсан өөрчлөлтийг харуулахыг зорив.

Улаанбаатар хотод Монгол Улсын хүн амын 45% нь амьдарч байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд хотжилт эрчимтэй өрнөж байна. Хотжилт

гэж юуг хэлэх вэ? Хотжилт гэдэг нь хөдөө орон нутгийн хүн ам хот суурин газарт шилжин суурьшиж байгаа үйл явц төдийгүй тухайн шилжин суурьшигчдын амьдрах орчны асуудал байнга хөндөгдөж байдаг зохицуулалт шаардсан цогц хөдөлгөөн аж. Ийнхүү Улаанбаатар хотын хүн ам жилээс жилд өсөн нэмэгдэж, суурьшлын бүс өргөжин тэлсээр байгаа хэдий ч хотын амьдралын чанар, амьдрах орчин, аюулгүй байдал, засаглалын үзүүлэлт сайнгүй хэвээр байна. Авто замын түгжрэл, агаарын бохирдол; хүүхдийн тоглоомын талбай, сургууль цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагын

“

Хүмүүс мөрөөдлөө биелүүлэхээр зорин ирж байгаа улсын нийслэл Улаанбаатар хотын дүүрэг, хороод маань иргэдийнхээ мөрөөдлийг биелүүлэх ая тухтай амьдрах орчинтой, ажиллах таатай нөхцөлтэй, эдийн засгийн өргөн боломж сонголттой, засаглалын хувьд үлгэр жишээ газар байх ёстой юм.

үйлчилгээний хүртээмж зэрэг тулгамдсан асуудал өнөөдрийг хүртэл шийдлээ хүлээсээр олон Парламент, Засгийн газрын нүүр үзлээ.

Хөдөөгийн иргэд төрж өссөн нутгаа орхин хот уруу нүүдэллэж байгаа үндсэн шалтгаан нь амьдралын чанараа сайжруулах зорилго байдаг. Энгийнээр хэлбэл: тэд мөрөөдлөө биелүүлэхээр хотыг зорьдог. Гэвч бодит байдал өөр байна.

Хүмүүс мөрөөдлөө биелүүлэхээр зорин ирж байгаа улсын нийслэл Улаанбаатар хотын дүүрэг, хороод маань иргэдийнхээ мөрөөдлийг биелүүлэх ая тухтай амьдрах

орчинтой, ажиллах таатай нөхцөлтэй, эдийн засгийн өргөн боломж сонголттой, засаглалын хувьд үлгэр жишээ газар байх ёстой юм. Хотоо хөгжүүлэхэд дүүргийн удирдлага, иргэдийн үр ашигтай хамтын санаачилга, төлөвлөлт, оролцоо, шийдэл, хяналт нэн чухал байдаг тул хамтдаа өрсөлдөж мөрөөдлийн хотоо байгуулцгаая!



Пунцагийн Цагаан
Удирдах зөвлөлийн дарга



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв нь засаглал болон хөгжил хоорондын уялдаа холбооны талаарх бидний ойлголтыг сайжруулахад дэм болохуйц, Монгол улсад хийгдэж буй хамгийн чухал судалгаануудын нэгийг гүйцэтгэж байна. Монгол Улсын Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан болон Улаанбаатар хотын дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангах боломжийг бүрдүүлэхэд засаглал, бодлого зэрэг олон хүчин зүйлс хэрхэн нөлөөлж буй талаарх бидний ойлголтод чухал хувь нэмрийг оруулж байна.

Азийн сангийн зүгээс ч эдгээр судалгааны үр дүнг өргөн хүрээнд ашиглаж буй юм. Бид өөрийн хэрэгжүүлж буй төсөл,

хөтөлбөрүүдийг аль чиглэлд хандуулахаа тодорхойлох, засаглалд тулгараад буй сорилтуудад дүн шинжилгээ хийх, бизнес эрхлэгчдийн нүүр тулж буй бизнесийн орчныг судлах, нутгийн удирдлага, засаглалыг хөгжүүлэхэд дэмжлэг болохуйц үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх гээд олон чиглэлээр эдгээр судалгааны үр дүнг ашиглаж иржээ. Засаглал, эдийн засгийн өсөлтийн чадавх зэрэг ээдрээтэй асуудлуудын талаарх ямар ч бодит дүн шинжилгээнд нийгмийн шинжлэх ухааны суурь зарчмуудад тулгуурлан цуглуулж, боловсруулсан мэдээллийн хүртээмжтэй байдал чухал үүргийг гүйцэтгэдэг билээ.

Улаанбаатар хот нь Монгол Улсын асар их боломж хийгээд өнгөрөгч гурван аравны туршид

ихээхэн хурдацтай явагдаж буй өөрчлөлтүүдээс үүдсэн олон тооны сорилтуудын билэг тэмдэг болж үлдсэн. Өсөн нэмэгдэж буй баялаг, өргөжин сайжирч буй иргэдэд зориулсан үйлчилгээ, үүдэн гарч буй инноваци, бүтээлч байдлыг хот даяар харж болж байна. Үүний зэрэгцээ тэгш бус байдал нэмэгдэж, гэр хорооллын иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад сорилтууд тулгарч, замын хөдөлгөөн, утаа зэрэг асуудлууд бүрэн шийдэгдээгүй хэвээр байна.

Эдгээр сорилтууд нь Улаанбаатар хотөөрийн давуутал, боломжуудыг бодит үр дүн болгон хувиргахад сайн засаглал, үр дүнтэй бодлого хэрэгцээтэй буйг бидэнд сануулж байна. Үүнийг амжилттай хэрэгжүүлэх нь Нийслэлийн Засаг дарга, Улаанбаатар хотын захиргааны хүчин чармайлтаас хамаарахын зэрэгцээ 9 дүүргийн засаглалын үр дүнтэй гүйцэтгэлээс шалтгаалах юм. Нийслэлийн дүүргийн түвшинд засаглал нь ихэнх тохиолдолд дутуу үнэлэгдэж, нарийвчлан судлагдаж ирсэн. Иймээс Дүүргүүдийн өрсөлдөх

чадварын тайлан нь засаглалын талаарх хэлэлцүүлэгт дүүргүүдийг татан оролцуулах улмаар Улаанбаатар хотод өсөлтийг бий болгоход тус дэм үзүүлж байна.

Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан нь амьдралын чанар, амьдрах орчин, аюулгүй байдал, засаглал болон эдийн засаг гэсэн үндсэн 5 бүлгийг хамарч судалдаг. Өрсөлдөх чадварын энэхүү цогц аргачлал нь хот хэрхэн хөгжиж, өөрчлөгдөж, хэрэгжүүлсэн бодлого нь иргэдэд ямар бодит нөлөө үзүүлж буйг харуулах чухал мэдээлэл болох юм. Судалгааны мэдээлэл нь судлаачид, төрийн албан хаагчид, төрийн бус байгууллагууд болон Улаанбаатар хотын иргэдийн анхаарлыг ихээр татах нь дамжиггүй. Азийн сангийн зүгээс энэхүү чухал ач холбогдолтой мэдээллийг цуглуулж, төрөл бүрийн хэрэгцээнд зориулан нэгтгэн танилцуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэндээ баяртай байна. Энэхүү тайланг уншигч хэн бүхэнд тайланд тусгагдсан мэдээллийг бодит ажил хэрэг болгох үйл хэрэгт нь өндөр амжилтыг хүсэж байна.



Марк Кэйниг

Монгол улс дахь Суурин Төлөөлөгч
Азийн Сан

ТОВЧИЛСОН НЭРСИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АХС	Ажиллах хүчний судалгаа
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МСҮТ	Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв
НБГ	Нийслэлийн боловсролын газар
НСГ	Нийслэлийн статистикийн газар
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
ТАШН	Түүврийн анхан шатны нэгж
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв
—	Мэдээлэл байхгүй

СУДАЛГААНЫ БАГ

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

П.Цагаан	Удирдах зөвлөлийн дарга
Б.Лакшми	Ерөнхий захирал
И.Одончимэг	Дэд захирал
Э.Тунгалаг	Судалгааны багийн ахлагч
Ч.Ганбат	Судлаач
Х.Есөнчулуу	Судлаач
Э.Золбаяр	Судлаач
Х.Отгон-Эрдэнэ	Судлаач
Ж.Хулан	Судлаач
Ч.Отгочулуу	Зөвлөх
Д.Оюунбилэг	Зөвлөх
И.Энхбаатар	Зөвлөх

УДИРТГАЛ

009

Хотжилт гэдэг үг хөгжил, дэвшил, шинэчлэлт гэдэг үгстэй утга нэг ойлгогддог. Бид хотжилтыг хөдөө орон нутгаас шилжин ирэх хүний тоо нэмэгдэх төдийхнөөр ойлгодоггүй. Хотжилтыг бид илүү сайн амьдралын стандарт, илүү боломж гэж хардаг.

“

Харин Монгол Улсын хувьд 'хотжилт' гэх үзэгдэл яг хэрхэн тодорхойлогдож, ямар үр нөлөөг дагуулж байна вэ? Хотжилт иргэдийн амьдралыг сайжруулж, хүсэл мөрөөдлөө биелүүлэхэд нь тусалж чадаж байна уу?

Хотжилт бол улс орны хөгжлийн явцад гарч ирдэг зайлшгүй нэгэн үзэгдэл юм. Манай улсын нийт хүн амын 67.2 хувь нь хот суурин газар, 45.3 хувь буюу 2 хүн тутмын нэг нь нийслэл хотод амьдарч байна. Тэр дундаа нийслэл хотын нийт хүн амын 95.1 хувь нь төвийн 6 дүүрэгт амьдарч буй юм.¹

Нийт нутаг дэвсгэрийн ердөө 0.3 хувийг эзлэх Улаанбаатар хотод хүн амын дийлэнх нь

төвлөрч буйгаас харахад хотжилт үнэхээр эрчимтэй байна. Харин хотжилтын үр нөлөөг үнэлэхийн тулд түүнийг зөв тодорхойлох, олон талаас нь бодитоор хэмжих нь чухал. Улаанбаатар хотын дүүргүүдийн өрсөлдөх чадварын судалгааны үндсэн зорилго нь энэ билээ.

Дүүргүүдийн өрсөлдөх чадварыг судалж эхэлсэн 2 жилийн өмнөхтэй харьцуулахад нийслэл хотын хүн ам 2.7 хувь нэмэгдэж 1.4 сая иргэнтэй, 386 мянган өрхтэй болжээ.²

“

Улаанбаатар хотын өрсөлдөх чадварын ерөнхий индекс 0.557 болж, 2017 оны судалгаатай харьцуулахад 7 хувь нэмэгдсэн байна.

Өрсөлдөх чадварын индекс нь 0-1 хооронд утга авах ба 1 рүү дөхөх тусам өрсөлдөх чадвар сайтай гэж үздэг.


Улаанбаатар хотын өрсөлдөх чадварыг үндсэн 5 бүлгээр харвал эдийн засаг, амьдралын чанарын хувьд харьцангуй сайн буюу 0.6-

¹ Монгол Улсын хүн амын статистик, 2017, Үндэсний статистикийн хороо

² Улаанбаатар хотын хүн амын статистик, 2015, 2017 он, Нийслэлийн статистикийн газар

УДИРТГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ЕРӨНХИЙ ИНДЕКС, 2019



аас дээш оноотой, харин аюулгүй байдал, засаглал 0.5 орчим, амьдрах орчны хувьд 0.5-аас бага оноотой үнэлэгдсэн байна.

. . .

Манай улсын эдийн засгийн гол цөм нь яахын аргагүй Улаанбаатар хотод төвлөрч байна. Нийт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 64.2 хувь нь нийслэл хотод төвлөрч, улсын нийт ДНБ-ий 64.7 хувийг энд бүрдүүлж байна.³ Дүүргүүдийн судалгааны үр дүнгээс харвал эдийн засгийн төвлөрөл өндөр, иргэдийн амьжиргааны түвшний өөрчлөлтийн талаарх хүлээлт эерэг байгаа боловч ажилгүйдлийн түвшин өндөр, үнийн өсөлтийн иргэдийн

амьжиргаанд үзүүлэх дарамт их хэвээр байна. Нийт өрхийн 39 хувь нь сард 500 мянган төгрөгнөөс доош орлоготой байна.

Улаанбаатар хотыг зорих гол шалтгаанууд болох эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, эмнэлэг, сургуулийн орчин, нөхцөл хөдөө орон нутагтай харьцуулахад сайн байгаа хэдий ч эмнэлгийн ачаалал өндөр байгааг судалгааны үр дүнгээс харж болно. Мөн ЕБС-ийн хамран сургалт сайн байгаа бол цэцэрлэгийн хамран сургалтын хувь тун хангалтгүй гарчээ. 2017 оны байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд 2-5 насны нийт хүүхдийн 78 хувь нь цэцэрлэгт хамрагдаж байна. Мөн төрийн өмчийн цэцэрлэгийн сурагч багшийн харьцаа өндөр (нэг багшид ногдох сурагчийн тоо

³ 2017 оны байдлаар, Үндэсний статистикийн хороо

38) байна. Цэцэрлэг, сургуулийн хүртээмж өмнөх судалгаатай харьцуулахад сайжирч байгаа хэдий ч хүн амын өсөлтийн хурдыг гүйцэхгүй байна.

Улаанбаатар хот хэр аюулгүй, амар тайван хот вэ? Хүн амын тоотой харьцуулж харвал нийслэл хотод гэмт хэргийн тоо хөдөө орон нутгаас өндөр байдаг. Түүнчлэн 2 жилийн өмнөх судалгаатай харьцуулахад гэмт хэргийн гаралт нэмэгдсэн, илрүүлэлт буурсан байна. Харин залуусын гэмт хэрэгт холбогдох байдал багасах хандлагатай болжээ. Мөн хууль ёс хүн бүрт тэгш үйлчлэх байдлыг иргэд 3.8 оноогоор үнэлсэн нь тун тааруу үзүүлэлт байна.

Аюулгүй амьдрах нэг нөхцөл нь эрүүл, цэвэр орчинд амьдрах явдал билээ. Гэтэл Улаанбаатар хотын иргэд эрүүл орчинд амьдарч чадахгүй байна. Агаарын бохирдол, ил задгай хог хаягдал, дуу чимээний бохирдол зэрэг үзүүлэлтийн үнэлгээ доогуур байгаа нь үүнийг илтгэж буй юм.

Хотжилтын нэг том давуу тал нь ая тухтай амьдралын стандартыг бий болгох байдаг. Одоогийн байдлаар Улаанбаатар хотын нийт өрхийн 44 хувь нь орон сууцанд буюу төвлөрсөн системд холбогдсон бол 27 хувь нь монгол

гэрт амьдарч байна. Хамгийн сонирхолтой нь энэ үзүүлэлт 10 жилийн өмнөхтэй харьцуулахад бараг өөрчлөгдөөгүй (2007 онд нийт өрхийн 26 хувь нь монгол гэрт амьдарч байсан 4) байгаа юм.

Иргэд хот төлөвлөлтийн оновчтой байдалд дунд үнэлгээ өгч байна. Ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, явган хүний зам зэрэг үзүүлэлтүүд тун хангалтгүй байгаа нь уг үнэлгээнд нөлөөлжээ.

Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад дүүрэг, хорооны цахим засаглал, мэдээллийн нээлттэй байдал нэмэгдэж, түүнийг даган дүүрэг, хорооны үйл ажиллагааны хүртээмж сайжирсан хэдий ч дүүргүүдийн төсвийн удирдлага, иргэдийн төсвийн эрх мэдэл сул хэвээр байна.

. . .

Ийнхүү нэг талаас хотжилт эрчимжих буюу хотод амьдрах иргэдийн тоо, хүн амын нягтрал нэмэгдэх үзэгдэл явагдаж байна. Харин хотжилтын чанарын хувьд хотод амьдарч буй иргэдийн

4 Нийслэлийн статистикийн эмхтгэл, 2007, Нийслэлийн статистикийн газар

амьдралын стандарт нь хүн амын өндөр нягтралаас хамааран буурахгүй байх, сонголт хийх боломж нь хязгаарлагдахгүй байх учиртай ч энэ нь бодит байдалд төдийлөн хангагдахгүй байна.

“

Хотжилт илүү сайн амьдралын стандартыг сонгох боломжийг нээж байгаа нь үнэн ч энэ нь хүн бүрт хүртээмжтэй бус байна.

Хотжилтын эерэг нөлөөг илүү хүртээмжтэй байлгах, хотын болон дүүргүүдийн өрсөлдөх чадварыг тогтвортой хөгжүүлэх нь урт хугацаанд анхаарах гол асуудал юм.

...

Дүүргүүдийн хувьд өрсөлдөх чадварын ялгааг харвал ерөнхийд нь гурван түвшинд ангилж болно. Үүнд:

- өрсөлдөх чадварын хувьд харьцангуй сайн буюу Хан-Уул, Баянгол, Баянзүрх дүүргүүд (өрсөлдөх чадварын индекс нь 0.510-аас дээш оноотой),
- өрсөлдөх чадварын хувьд дундаж Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргүүд

(өрсөлдөх чадварын индекс нь 0.460-0.510 хооронд оноотой)

- алслагдсан дүүргүүд болох Багануур, Налайх, Багахангай дүүрэг (өрсөлдөх чадварын индекс нь 0.460-аас бага).

Өөрөөр хэлбэл нийслэл хотын дүүргүүдийн өрсөлдөх чадвар харилцан адилгүй хэмжээнд байгаа нь мөн анхаарал хандуулах асуудал гэж харагдаж байна.

...

Улаанбаатар хотын өрсөлдөх чадварыг сайжруулах, дүүргүүдийн өрсөлдөх чадварын ялгааг арилгахын тулд судалгааны үр дүнг тогтмол хэмжиж, өрсөлдөх чадварын сул үзүүлэлтэд илүү анхаарал хандуулан ажиллах шаардлагатай.

“

Хүн амын хэт төвлөрлөөс үүдсэн асуудлаар дүүрэн бус харин хүн бүрсэтгэл хангалуун амьдрах боломжоор дүүрэн хотыг бид хүсэж байна.



01

СУДАЛГААНЫ ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ



Судалгааны зорилго

Судалгааны үндсэн зорилго нь нийслэл Улаанбаатар хотын 9 дүүргийн өрсөлдөх чадварыг судалгааны хүрээнд тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдээр тооцсон нэгдсэн индексээр үнэлэн, дүүргүүдийн болон Улаанбаатар хотын өрсөлдөх чадварыг тодорхойлох, өрсөлдөх чадварын давуу, сул талууд, түүнийг сайжруулахад тулгарч буй бэрхшээлүүдийг гаргаж ирэхэд оршино.

Судалгааны үр дүнд үндэслэн дүүрэг, нийслэлийн удирдлагуудыг бодитой мэдээллээр хангах, дүүрэг, нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд ашиглахуйц гарын авлага бий болгох, урт хугацааны хөгжлийн загварыг бий болгоход дэмжлэг үзүүлэхэд судалгааны зорилго хамаарна.



ДҮҮРГҮҮДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өрсөлдөх чадвар судлал нь маш өргөн хүрээтэй ойлголт бөгөөд аливаа улс, бүс нутгийн өрсөлдөх чадварыг тодорхойлж хэмжихдээ “эдийн засгийн бус” хүчин зүйлсийн нөлөөг нэмж тооцдоггоороо эдийн засгийн онолд хувь нэмрээ оруулж буй салбар шинжлэх ухаан юм. Өөрөөр хэлбэл улсын, аймгийн, дүүргийн гэх мэт янз бүрийн түвшний өрсөлдөх чадварыг тодорхойлох судалгаанууд нь тухайн бүс нутгийн хөгжлийн түвшинг эдийн засгийн болон эдийн засгийн бус шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан цогц байдлаар үнэлэх боломж олгодог.

Дүүргүүдийн өрсөлдөх чадварыг үнэлэхдээ энэхүү суурь зарчимд үндэслэн дүүргүүдийн буюу хотын хөгжлийн түвшинг цогц байдлаар хэмжих зорилгыг тавьж шалгуур үзүүлэлтүүдийг сонгосон болно.

Дүүрэг, хотын хөгжлийн тухай ойлголт, түүнийг хэмжих тухай

асуудал нь хотжилтын хурдацтай хөгжил, хотжилтын хувьслыг даган өдөр ирэх тусам өргөжин тэлж, өөрчлөгдөж байна.

Орчин үеийн хот гэдэг ойлголт нь зөвхөн өндөр шилэн барилгууд баригдаж, үйлдвэрлэл үйлчилгээ төвлөрсөн газрыг хэлэхээ больж хүний хөгжлийг дээдэлсэн, иргэн бүрт хүртээмжтэй, эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах орчин бүхий хотжилтыг бий болгоход улс орнууд анхаарч байна. Үүнээс гадна байгаль орчинд ээлтэй ногоон хот, амьдрахад илүү амар хялбар, цаг хугацаа хэмнэсэн ухаалаг хотын талаар судалгаанууд хийгдэх болжээ.

Иргэдээ эрүүл, боловсролтой, тогтмол орлоготой байхад буюу иргэдийн амьдралын чанарт анхаарах нь хотын хамгийн чухал асуудал бөгөөд дэд бүтцээр хангагдсан, аюулгүй, эрүүл, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх нь зайлшгүй нөхцөл юм. Харин



Хүний хөгжлийг
дээдэлсэн



Амьдрах орчин
ая тухтай



Дэд бүтэц хөгжсөн,
аюулгүй

иргэдийн амьдралын чанар, амьдрах орчин сайн байх суурь нөхцөл нь засаглалын үр ашиг хүртээмжтэй байж, бизнес эрхлэх таатай орчин бүрдсэн, эдийн засгийн чадавхи өндөр байх явдал билээ.

Энэхүү судалгааны хүрээнд дүүргүүдийн өрсөлдөх чадварыг хэмжихдээ амьдралын чанар, амьдрах орчин, аюулгүй байдал, засаглал, эдийн засаг гэсэн таван үндсэн бүлэг, тэдгээрийг нарийвчлан үнэлэх тус бүр гурван дэд бүлэг буюу нийт 15 дэд бүлгийн хүрээнд нарийвчлан тодорхойлсон нийт 150 шалгуур үзүүлэлтээр хэмжсэн.

Амьдралын чанар бүлэгт дүүргийн иргэдийн амьжиргааны түвшин, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэх 29 шалгуур үзүүлэлт ашигласан.

Амьдрах орчин бүлэг нь хот төлөвлөлт, хотжилт, дэд бүтэц, иргэдийн амьдарч буй орон сууцны нөхцөл байдал, орчны тохижилт, соёлын асуудлуудыг үнэлэх ба нийт 49 шалгуур үзүүлэлттэй.

Аюулгүй байдал бүлгийн хүрээнд иргэд амар тайван, аюулгүй орчинд амьдрах боломж бүрдсэн эсэх хийгээд ногоон хотжилтын түвшинг үнэлэх 30 шалгуур үзүүлэлтийг ашигласан.


Засаглал бүлэг нь дүүргийн төсөв, институцийн тогтолцоо, нийгмийн тогтолцоог үнэлэх ба 31 шалгуур үзүүлэлттэй.

Эдийн засаг бүлэгт дүүргийн эдийн засгийн чадавхи, хөдөлмөр эрхлэлт, бизнесийн идэвхжлийг үнэлэх 11 шалгуур үзүүлэлт ашигласан.

Дүүргүүдийн өрсөлдөх чадварын шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг хавсралтаас харна уу.



Хотын
соёлтой



Бизнесийн таатай
орчин бүрдсэн



Засаглалын үр
ашиг сайн



Эдийн засгийн
чадавхи өндөр

ДҮҮРГҮҮДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ҮНДСЭН 5 БҮЛЭГ, 15 ДЭД БҮЛЭГ

1 АМЬДРАЛЫН ЧАНАР



- Амьжиргааны түвшин
- Эрүүл мэнд
- Боловсрол

2 АМЬДРАХ ОРЧИН



- Хотжилт
- Үндсэн дэд бүтэц
- Соёл

3 АЮУЛГҮЙ БАЙДАЛ



- Амар тайван байдал
- Аюулгүй орчин
- Эрүүл орчин

4 ЗАСАГЛАЛ



- Төсөв
- Институцийн тогтолцоо
- Нийгмийн тогтолцоо

5 ЭДИЙН ЗАСАГ



- Эдийн засаг
- Хөдөлмөр эрхлэлт
- Бизнесийн идэвхжил

Дүүргүүдийн өрсөлдөх чадварын шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг хавсралтаас харна уу.

МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

019

Дүүргүүдийн өрсөлдөх чадварын судалгаа нь өрсөлдөх чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийг дараах хоёр төрлийн эх үүсвэрээс бүрдүүлсэн. Үүнд:

1. Дүүргүүдийн албан ёсны статистик мэдээлэл
2. Өрхийн асуулга

Дүүргүүдийн өрсөлдөх чадварыг үнэлэх 150 шалгуур үзүүлэлтийн ойролцоогоор 1/3 нь статистик мэдээлэл, 2/3 нь санал асуулгын мэдээлэл байна. Мөн статистик мэдээлэл дотор өрсөлдөх чадварын үнэлгээнд орохгүй, зөвхөн нэмэлт мэдээлэл өгөх зорилготой ерөнхий үзүүлэлтүүд байна.

Статистик мэдээлэл нь өрсөлдөх

чадварыг тодорхой хугацаанд (өнгөрсөн нэг жилд гэх мэт) хэмжиж харуулдаг ба өрсөлдөх чадвар ямар түвшинд байгааг илэрхийлдэг. Харин санал асуулгаар статистик мэдээллийн олдоц муу, шууд хэмжихэд бэрх тоон бус үзүүлэлтүүдийг тодорхойлж олж авдаг онцлогтой. Түүнчлэн санал асуулгын мэдээлэл нь тухайн статистик мэдээллүүдийг батлах, бодит байдлыг тодруулах, иргэд, хувийн хэвшлийнхэн тухайн үзүүлэлтийг хэрхэн үнэлж буйг харуулах ач холбогдолтой. Тиймээс “өнгөрсний дүр зураг” болдог статистик тоон үзүүлэлттэй харьцуулахад санал асуулга нь бодит байдалд илүү дөхөм, цаг хугацааны хувьд илүү шинэлэг байдаг.

Дүүргүүдийн өрсөлдөх чадварын шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг хавсралтаас харна уу.

Судалгааны санал асуулгын мэдээллийг өрхийн асуулгаар цуглуулсан ба нийслэлийн нийт есөн дүүргийг хамарсан түүвэр судалгааг зохион явуулсан. Түүвэр судалгааг хоёр шатат, энгийн санамсаргүй түүврийн аргаар хийсэн.

Түүврийн дизайн нь өмнөх судалгаатай ижил зарчмаар

тодорхойлогдсон. Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2017 судалгааны гол үзүүлэлтүүдийн хувьд түүврийн алдааны хязгаар, дизайны нөлөө нь дүүргүүдийн түвшинд төлөвлөж байсан хэмжээнд гарсан тул түүврийн хэмжээ, дизайныг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

ТҮҮВРИЙН ХҮРЭЭ

Судалгааны зорилгод нийцсэн түүврийн хүрээ нь Улаанбаатар хотын нийт өрх буюу дүүргүүдээс үйлчилгээ авагч, хэрэглэгчид

юм. Түүврийн эх олонлогоор Улаанбаатар хотын 2017 оны жилийн эцсийн хүн ам, өрхийн тоог авсан.

УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМ, ӨРХИЙН ТОО, ДҮҮРГЭЭР, 2017

	ӨРХИЙН ТОО	ХҮН АМ
Багануур	8,514	28,787
Багахангай	1,196	4,100
Баянгол	58,756	221,384
Баянзүрх	94,971	336,932
Налайх	10,547	36,911
Сонгинохайрхан	86,212	322,458
Сүхбаатар	38,272	138,047
Хан-Уул	47,202	169,726
Чингэлтэй	40,548	159,051
Улаанбаатар	386,218	1,417,396

Эх үүсвэр: ҮСХ

ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ

Дүүргүүдийн өрсөлдөх чадварын судалгааны түүврийг энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгосон. Энгийн санамсаргүй түүвэр буюу нийт эх олонлогоос

судалгаанд хамруулах өрх бүрийг тэнцүү магадлалтайгаар сонгох тохиолдолд түүврийн хэмжээг дараах томъёогоор тооцно.